

Зураг үйлдэх ерөнхий журам

Алба ажиллагааг зохион байгуулах ба тактикийн өгөгдэхүүнүүдийг оруулан тэмдэглэсэн газар орны зураглал бүхий алба ажиллагааны баримт бичгүүд өргөн хэрэглэгддэг.

Ийм баримт бичгүүд нь цагийн байдлын тухай нүдэнд харагдахуйц тодорхой мэдээнүүдээр эх бичиг бүхий баримт бичгүүдийг гүйцээн тайлбарлах ба зарим тохиолдолд эдгээрийг өөрчлөн халдаг.

Алба ажиллагааны баримт бичгүүд үйлдэх буюу хөтлөх байр зүйн үндэс нь гол төлөв байр зүйн зургууд, түүнчлэн бусад бүдүүвч, схем, тойм, газар орны жирийн зураглалууд болж өгдөг.

1. Зургийн төрөл

Алба ажиллагааны баримт бичгүүдийг тэдгээрийн байр зүйн үндэс ба үйлдэгдэх аргаас нь хамаарч дор дурьдагдах төрлүүдэд хувааж болох юм. Үүнд:



Зураг



Бүдүүвч ба зураглал, (нүдэн баримжааны зураг, тойм, схем)

Тухайлбал ийм баримт бичгүүдэд хамгийн түрүүнд тактикийн хэрэгцээтэй өгөгдэхүүнийг оруулан тэмдэглэх замаар шууд байр зураг дээр үйлдэгдэх буюу хөтлөгдөх баримт бичгүүд хамаарна.

1. **Цагийн байдлын зураг** гэдэг нь агаарын зураг (аэроснимок) буюу мэдээллийн замаар олж авсан газар орны тухай мэдээнүүдийг нэгтгэн дүгнэж, шалган магадлаад зурагт оруулан тэмдэглэсэн, эсвэл хэвлэсэн жирийн байр зүйн буюу бланкийн зураг юм. Бланкийн зураг гэдэг нь жинхэнэ өөрийн нь буюу эсвэл арай томсгосон хэмжээтэйгээр гол төлөв нэг, зарим тохиолдолд 2-3 бүдэг өнгийн будгаар хийгдсэн байр зүйн хуулбар зураг юм.
2. **Бүдүүвч** Ихэвчлэн байр зүйн ба агаарын зурагт тулгуурлан тэдгээрийн хэмжээсийг ойролцоогоор хадгалан хийгдсэн газар орны дүрслэл бүхий баримт бичгүүдийг **бүдүүвч** гэнэ.

Тойм зураг *Хэргийн газрын тойм зураг болохоос биш масштабын зураг биш.*

Ийм байдлаар байр зүйн ба агаарын зургийн тусламжтайгаар үйлдэгдсэн бүдүүвчүүдийг шаардлагатай үед жинхэнэ газар орон дээр нь магадлан үзэж нүдэн баримжаагаар засварлана.

Бүдүүвчинд зөвхөн үйлдэгдэж байгаа баримт бичигт шаардлагатай газар орны зүйлс, газрын гадаргуун хэлбэр дүрс бүхий элементүүдийг дүрслэн үзүүлнэ.

Байр зүйн ба агаарын зургийн тусламжтайгаар газар орны бүдүүвч хийх арга барил

Бүдүүвчийн зориулалтаас хамаарч байр зүйн ба агаарын зургийн хэмжээстэй ижил хэмжээстэйгээр юмуу эсвэл өөрчилсөн хэмжээсээр (гол төлөв томсгосон) бүдүүвчийг үйлдэнэ.

Бүдүүвчийг зургийн хэмжээсийн дагуу үйлдэхэд калька гэрэлтэгч цаасанд газар орны хэрэгцээтэй зүйлс, тэдгээрийн утга агуулгыг хуулбарлан буулгах замаар хийх нь илүү зохимжтой хялбар байдаг. Зургаас үл гэрэлтэгч цаасанд хуулбарлан буулгах замаар бүдүүвч хийх үед гол төлөв цонхны шил зэрэг оруулах гэрэлтэгч материалыг ашиглана.

Гэрэлтэгч цаас байхгүй, цонхны шил мэтийг ашиглах гэрэлтэгч материал байхгүй тохиолдолд бүдүүвчийг доорхи байдлаар үйлдэнэ. Үүнд:

Цэвэр цаасан дээр зураг дээрх тэгш өнцөгт солбицлолын тортой ижил хэмжээтэй дөрвөлжин нүднүүд (квадрат) үүсгэх торыг татаж, уг торын шугамуудыг зураг дээрхи торын шугамтай адилаар дугаарлан тэмдэглэнэ.

Дараа нь сантиметрийн (миллиметрийн) хуваарьтай шугам ба хэмжигч ац (циркуль)-ын тусламжтайгаар үйлдэгдэх бүдүүвчинд шаардлагатай зүйлс, солбицлолын торын дөрвөлжин нүднүүдэд хэсэгчлэн нүдэн баримжаагаар буудгаж зурна. Хэрвээ бүдүүвч нь хэд хэдэн ширхэгээр шаардагдаж байвал түүнийг хортой цаас ашиглаж хийнэ.

Зургийн хэмжээсийг өөрчлөн бүдүүвчийг хийхэд ихэвчлэн дөрвөлжин нүд бүхий торыг ашиглан хийнэ. Үүнд:

1. Байр зүйн буюу агаарын зураг дээр бүдүүвчинд дүрслэгдэн байвал зохих газар орны хэсгийг тэгш өнцөгт дүрсээр хүрээлэн зурна.
2. Үүнтэй төсөөтэй тэгш өнцөгтийн бүдүүвч хийх цаасан дээр хэрэгцээтэй тоо дахин ихэсгэж (эсвэл багасгаж) зурна.
3. Бүдүүвч хийх цаасан дээр зурагдсан тэгш өнцөгт дотор байр зүйн зураг дээрх солбицлолын тортой харьцангуйгаар бүдүүвчийн хэмжээсэнд тохирох торыг байгуулна.

4. Хэмжигч ац (циркуль) ба миллиметрийн хуваарьтай шугамын тусламжтайгаар (агаарын зураг дээр бол шаантаг хэмжээсийн тусламжтайгаар) байр зүйн зургаас газар орны хэрэгцээтэй зүйлсийг бүдүүвч хийж байгаа цаасанд торын дөрвөлжин нүднүүдээр шилжүүлэн буулгана.

Хэрвээ энэ агаарын бүдүүвчийг үйлдэхэд нэлээд өндөр нарийвчлалт шаардагдаж байвал зургаас газар орны элементүүдийг бүдүүвч хийж байгаа цаасанд шилжүүлэн буулгахдаа доорхи аргыг ашиглана. Тухайлбал:

Байр зүйн зураг дээрх ба бүдүүвч үйлдэх цаасан дээр татагдсан солбицлолын торын дөрвөлжин нүднүүдийг дотор нь бас дахин ижил хэмжээтэй олон жижиг дөрвөлжин нүднүүдэд хуваагаад, дараа нь энэ байгуулсан тороо ашиглан хэрэгцээтэй зүйлсийг зургаас уг цаасанд нүдэн баримжаагаар хуулбарлан буулгана. Харин бүдүүвчийг үйлдэж дуусгаад түүнийг чимэглэхдээ жижиг дөрвөлжин нүднүүд үүсгэсэн шугамуудыг арилгаж, зөвхөн солбицлолын торын шугамуудыг үлдээнэ.

Нүдэн баримжааны зураг

Энэ нь газар орны их биш талбайн хэсгийг хээр жинхэнэ газар дээр нь газар орны нэг буюу хоёр цэг дээрээс нүдэн баримжааны зураг зурах замаар, ойролцоо хэмжээстэйгээр хийж гүйцэтгэсэн зураглал юм. Нүдэн баримжааны зурагт бүх зайг зураглал дээр нүдэн баримжаагаар хэмжиж авна.

Бут, бутлаг ургамалыг 3-н талд нь хоорондоо 120 градус орчим зайтай байрласан гурван цэгтэй зууван дугуйгаар дүрслэнэ.

Үргэлжилсэн их ойг дүрслэх үед зууван дугуйг аль болохоор олныг зурж тэдгээрийг цэгээр холбож өгнө.

Хот тосгон, суурин газрыг их тодорхой дүрслэн үзүүлэх шаардлагагүй үед байшингуудыг дүрслэхгүйгээр тэднийг зөвхөн орон сууцны хороолол ба түүний хэсгүүдээр (кварталаар) нь дүрслэнэ.

Авто тээврийн замууд нь нэг шугам бүхий томьёолсон тэмдгээр дүрслэгдэж байвал хот тосгон, суурин газрын гудамж хүртэл зурагдаж таслагдаад, дараа нь уг гудамжны нөгөө үзүүрээс дахин үргэлжлүүлэн зурагдана. Авто тээврийн замууд (авто зам, сайжруулсан засмал зам, засмал зам, сайжруулсан хөрсөн зам) ба төмөр зам зэрэг нь зэрэгцээ хоёр шулуунаар дүрслэгдэж байвал өөрийнхөө бүх зураглалдаа тасралтгүй үргэлжилсэн байдлаар зурагдана. Хоёр зэрэгцээ шулуунаар дүрслэгдэгч зам нь ойн хүрээвч (хил хязгаар) гол мөрний эргийн шугам болон бусад томьёолсон тэмдгүүдтэй огтлолцох ёсгүй.

Төмөр зам нь түүний урсгалын тоог (хөдөлгөөний үндсэн шугам) заагч 1,2 ба 3 богино хөндлөн зураастай нэг өргөн хар шугамаар дүрслэгдэнэ.

Ганц мод, зам заагч, фабрик,, завод, уурын зуухны яндан ба нуга, хатсан буюу шатсан ой, огтлогдсон ой гэх мэтийн зүйлүүдийг томьёолсон тэмдгүүдийн босоо тэнхлэгийн нь зураглал үйлдэж байгаа цаасны дээд талын ирмэгт (хүрээнд) перпендикуляр байдлаар зурна.

Гол мөрөн, суваг шуудууны эргийн шугамууд нь гүүр, гарц, гарам, усны боомт, далан болон бусад орон нутгийн тодорхой зүйлсийн томьёолсон тэмдгийг огтолж гарахгүй.

Нуга, үргэлжилсэн бут, тариалангийн талбай зэргийн хил хязгаарыг дүрслэгч хүрээвч нь 0,5 мм орчим урттай богинохон тасархай зураасуудаар тэмдэглэгдэнэ.

Намгийн дүрслэн үзүүлэгч зураасууд нь цаасны дээд талын ирмэгтэй зэрэгцээгээр, харин хужирхаг газар, нуга зэргийг дүрслэгч зураасууд нь цаасны дээд талын ирмэгт перпендикуляр байдлаар зурагдана.

Гол мөрөн, суваг шуудуу ба газар нутгийн нэрээс бусад нэр, товчилсон бичлэг бүхий тайлбарлах томьёолсон тэмдгүүдийг цаасны дээд талын ирмэгтэй зэрэгцээгээр байрлуулж стандартын шрифтээр бичиж тэмдэглэнэ.

Үргэжлэл бий